

СОЁМБО МЭДЭЭ

"СОЁМБО" РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.03.10 №05 (05)

ҮЙЛ ЯВДАЛ

"ОЧ" ХАМТЛАГИЙН ГИШҮҮДИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "Оч" хамтлагийн гишүүдийг хүлээн авч уулзлаа. Энэ жил тус хамтлаг байгуулагдсаны 44 жилийн ой тохиолдож байна.

Уулзалтын үеэр МУГЖ Д.Жаргалсайхан "Тус хамтлаг 1977 онд хуучнаар Сэргэлэнгийн дивиз буюу Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд хугацаат цэргийн алба хааж байсан байлдагчид байгуулсан юм. Тухайн үед улс

төрийн агуулгатай дугаараа Монголын ард түмэнд төдийгүй гадаад улс орнуудад танигдаж, эх орныхоо нэрийг олон улсын урлагийн тайзнаа мандуулж явсан дайчин түүхтэй. "Оч" хамтлаг нь 1979 онд Болгар болсон олон улсын улс төрийн дууны тэмцээнд оролцоод зогсохгүй тухайн үед Элчин сайд байсан залуу жанжин Ж.Лхагвасүрэнтэй уулзаж, гар барьж явснаа одоо ч бид дурсах дуртай" гэж хэлсэн юм.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "Оч" хамтлагаас улбаалан түүчээлсэн оч өнөөдөр алдарт "Чингис хаан" хамтлаг болж, өргөжин хөгжжээ. Байлдагчдаас бүрдсэн хамтлаг гэхэд тухайн үед улсдаа төдийгүй гадаад орнуудаар аялан тоглож, үнэхээр л үеийн залуусаа манлайлан үлгэрлэж явсан гайхамшигтай түүх бол яахын аргагүй та нарынх юм. Цэрэг, эх орны сэдэвт уран бүтээлүүдээрээ

залуу үеийг соён гэгээрүүлж байсан гавьяаг тань Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний удирдлагууд хэзээ ч мартаггүй" хэмээн тодотгов.

Дараа нь хамтлагийн гишүүд МУГЖ Д.Жаргалсайхан, бэлтгэл ахлагч Ц.Болд, Д.Энхтүвшин, Д.Энхболд, Ц.Энхжаргал, А.Нацагдорж, Р.Ганбаатар, Д.Жаргал, И.Энхболд нарыг "Дайчин алдар-I", "Дайчин алдар II" медалиар шагналаа.



ЗЭВСЭГТ ХҮЧИН-100

"МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР", ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 100 ЖИЛИЙН ОЙГООР...

Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярын хурал энэ сарын 17-ны өдөр Төрийн ордны Их танхимд зохион байгуулагдах юм.

Зэвсэгт хүчнийг сурталчлах үүднээс үүдний хэсэгт ЗХЖШ, Төрийн цэргийн командлалууд, Монгол цэргийн музейн сурталчилгааны самбар, эд өлгийн зүйлсийг

Х Хурлыг албан ёсоор нээж Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр үг хэлэх бол ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг "Монгол Улсын Зэвсэгт хүчний түүхэн замнал, ирээдүйн хөгжлийн чиг хандлага" сэдвээр илтгэл тавих ажээ. Үргэлжлээд Төрийн дээд одон, медалиар шагнагдсан цэргийн алба хаагчдад шагнал



байрлуулах ажээ. Цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч хүний хамралтыг анхаарч байгаа бөгөөд танхимын үзэгчид болон онлайн үзэгчид гэсэн хувилбараар тооцон бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

гардуулах бөгөөд ЦДБЭЧ-ын уран бүтээлчдийн Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 100 жилийн ойд зориулсан урлагийн хэсэгчилсэн тоглолтоор баярын хурал өндөрлөх юм.

ҮЙЛ ЯВДАЛ

ХУРАНДАА ЦОЛ ОЛГОЛОО



ЗХЖШ-ын даргын тушаалаар өнгөрсөн хоёрдугаар сард эрхэлсэн албандаа үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим дэд хурандаад албан тушаалын зэрэглэлийн хурандаа цол олгосон билээ. Энэ үеэр албан томилолттой байсан ЗХЖШ-ын Материал, техникийн газрын Хэмжил зүйн албаны дарга, дэд хурандаа Ч.Бат-Эрдэнэд хурандаа цолыг нь ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг гардууллаа. Хошууч генерал Д.Ганзориг "Хурандаа цол үүрэг, хариуцлагатайгаа хамт танд очиж байна гэж ойлгоорой. ЗХЖШ-ын бүтцэд шинээр байгуулагдсан Хэмжил зүйн албыг зүгшрүүлэх, бидний

өмнө хүлээж байгаа олон ажлыг гүйцэтгэхийн төлөө идэвх санаачилгатай ажиллаарай" гээд цаашдын албанд нь өндөр амжилт хүссэн юм.

Хурандаа Ч.Бат-Эрдэнэ нь Зэвсэгт хүчинд 28 дахь жилдээ алба хааж байгаа бөгөөд баярын сэтгэгдлээ хуваалцахдаа "Энэ эрхэм цолны эзэн нь болж гялалзахын төлөө хичээж ажиллана. ЗХЖШ-ын дарга ч гэсэн энэ сайхан цол танд эрх мэдлээс илүү их үүрэг, хариуцлага хүлээлгэж байгаа шүү гэсэн. Зэвсэгт хүчинтэй ажил, амьдралаа холбосон нийт бие бүрэлдэхүүндээ удахгүй тохиох орчин цагийн Зэвсэгт хүчний түүхт 100 жилийн ойн баярын мэнд хүргэе" гэсэн юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-3°C	-10°C

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
41°C	28°C

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
12°C	2°C

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,845.0	2,858.0
EUR	3,351.0	3,416.0
CNY	433.20	438.00
RUB	37.49	39.21
JPY	25.85	26.49
KRW	2.44	2.56

КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	36
НИЙТ БҮРТГЭГДСЭН	3372
ЭДГЭРСЭН	2765
НАС БАРСАН	7

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	32
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	178
ЭДГЭРСЭН	842

ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.03.10 /ЛХАГВА ГАРАГ/

ХАВРЫН ТЭРГҮҮН ЦАГААН БАР САРЫН ХОЁР ХАР УЛААГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулвал: **Өлзийтэй сайн**

Наран ургах, шингэх: **07.15-18.50**

Барилдлага: **Идэр Шүтэн барилдлага: Нэр өнгө Суудал: Уул**

Аргын тооллын 3 сарын 10, Буд гараг. Билгийн тооллын 27, Яруу эгшигт одтой, улаагчин могой өдөр. Өдрийн наран 7 цаг 15 минутад мандан, 18 цаг 50 минутад жаргана. Тухайн өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, хараал, жатхыг буцаах, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх зэрэг үйлд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогосод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.



ЗЭВСЭГТ ХҮЧИН-100

25 ШҮЛГЭН ХҮЛЭГ “УРАЛДАНА”



Т.Баянсан, А.Лхагва, С.Жанцанхорол, Б.Цэрэнжамц, Ц.Отгонбаатар, Х.Дугарсүрэн, Ш.Даваадамдин нарын 25 найрагч тунасан бөгөөд тэд наадмын II шатанд халдвар хамгааллын дэглэмээ баримтлан шүүгчдийн өмнө шүлгээ уншиж өрсөлдөх юм.

Хоёрдугаар шатны шалгаруулалт нь МҮОНРТ-ээр “Монгол цэргийн өдөр” буюу гурав дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд орон даяар цацагдана.

“Эх орны цэрэг-2021” яруу найргийн наадам нь цэрэг эх орны

БХЯ, ЗХЖШ-аас Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 110, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг угтсан олон арга хэмжээг цахим хэлбэрээр зохион байгуулж байгаагийн нэг нь “Эх орны цэрэг-2021” яруу найргийн наадам юм.

Жанжны сэлэмтэй яруу найргийн наадмын нэгдүгээр шатны шалгаруулалт энэ сарын 6-ны өдөр болж, 200 гаруй найрагчийн 590 бүтээлийг зохиолч, яруу найрагч, утга зохиол судлаачдаас бүрдсэн шүүгчид хэлэлцэн шүүж, 25 бүтээлийг нь

дараагийн шатанд шалгарууллаа.

Эхний шатанд бүтээлээрээ тунаж үлдсэн найрагчдын дунд Монголын зохиолчдын эвлэлийн шагналт яруу найрагчид болон Зэвсэгт хүчний алба хаагч, хугацаат цэргийн алба хаагчид багтжээ. Тодруулбал, байлдагч Б.Мөнх-Ирээдүй (110), Ч.Дагмидмаа, Ч.Дагвадорж, М.Амархүү, А.Сүлэгмаа, Л.Мягмарсүрэн, Н.Батжаргал, Ж.Гүнтэвсүрэн, Ж.Ганчимэг, Н.Гантулга, С.Зоригтбаатар, В.Нэргүй, У.Пүрэвсүрэн, Б.Жамбалдорж, С.Минжинсайхан, Б.Баттулга, Ш.Цогтсугар, П.Батнайрамдал,

сэдэвт яруу найргийн өв санг баяжуулах, цэргийн алба хаагчид, иргэд, хүүхэд залуучуудад төрөлх нутаг, тусгаар тогтнол, түүх соёлоороо бахархах сэтгэлийг төрүүлэх, цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, яруу найргийн шилдэг бүтээлүүдийг сурталчлан нийтийн хүртээл болгоход оршдог бөгөөд 1989 оноос тасралтгүй зохион байгуулагдаж байгаа юм.

Эх орон, цэрэг дайчдыг яруу тансаг үгээр магтан дуулдаг энэхүү наадмыг уламжлал ёсоор БХЯ, ЗХЖШ, ЦДБЭЧ, Монголын зохиолчдын эвлэл хамтран зохион байгуулж байна.

МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙ

“ЗЭВСЭГТ ХҮЧИН-100 ЖИЛ” ҮЗЭСГЭЛЭН ХОЁР ХЭСГЭЭС...



Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан Монгол цэргийн музейгээс “Зэвсэгт хүчин-100 жил” дижитал үзэсгэлэнг үзэгч олондоо өргөн барихаар бэлтгэж байна.

Тус үзэсгэлэн нь Ардын журамт цэргээс Монголын Ардын Арми, Монголын Зэвсэгт хүчин гэсэн үндсэн 2 хэсгээс бүрдэх аж.

1921 оны Ардын журамт цэргээс эхлээд өнөөгийн энхийг сахиулагчдын түүхэнд холбогдох архивын 100 гаруй баримт, 150 гаруй биет үзмэр, эд өлгийн зүйлсийг дэглэн үзүүлэхээс гадна

1200 гаруй гэрэл зураг, баримтат киног орчин үеийн дэвшилтэт техник, технологийг түлхүү ашиглан үзүүлэх аж.

Тус үзэсгэлэнд Монголын Үндэсний музей, Үндэсний төв архив, Батлан хамгаалахын төв архив, МАН-ын төв архивын сан хөмрөгөөс урьд өмнө нь үзэгчдийн хүртээл болж байгаагүй ховор түүхэн гэрэл зураг, архивын үнэт баримтууд, Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, Д.Чагдаржав, Д.Бодоо нарын хэрэглэж байсан түүхэн биет үзмэрийг дэглэн толилуулахаар зөжжээ.

Мэдрэгчтэй ухаалаг дэлгэц, холограмм төхөөрөмж,

ухаалаг зурагт мэдрэгчтэй яригч, аудио чихэвч, гэрэлт самбар, проектор зэргийг ашигласнаар 100 жилийн түүхэнд холбогдох гэрэл зураг, архивын баримтуудыг он дараалалын дагуу олноор байршуулж үзэгчид өөрийн сонголтоор хүссэн баримт материалтай танилцах боломжийг олгож байгаа нь тус үзэсгэлэнгийн гол онцлог, шинэлэг тал ажээ. “Зэвсэгт хүчин-100 жил” үзэсгэлэн нь энэ сарын 17-ны өдөр Төрийн ордонд, 19-ний өдрөөс Монгол цэргийн музейн түр үзэсгэлэнгийн зааланд дэглэгдэж үзэгч олны хүртээл болох юм.

ЦАХИМ ШУУДАНД

ДОРНЫН ГОВИЙН МӨРДЭСТ БҮСГҮЙЧҮҮД ХАМТРАН АЖИЛЛАНА

336 дугаар анги

Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн Эмэгтэйчүүдийн зөвлөл “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтаж, Дорноговь аймгийн ШШГЕГ-ын Удирдлага болоод эмэгтэйчүүдийн зөвлөлийн гишүүдийг урьж, хамтран ажиллах талаар санал бодлоо солилцлоо.

Мөн эмэгтэйчүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, өнөөгийн нийгмийн нэн тэргүүнд тавигдах асуудал болох хүүхэд, эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг явуулах арга хэмжээний

талаар Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудийн хөгжлийн газартай гэрээ байгуулан үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байгаа аж.

Үүний дараа “Их говийн гарнизон” нэрээрээ олноо алдаршсан тус ангийн “Алдарын танхим”, цэргийн гал тогоо, ангийн эмнэлэг, цэргийн байртай танилцаж, хээрийн байрлалд сургалт, дадлагад хамрагдаж байсан ангийн эмэгтэй цэргийн алба хаагчидтай уулзаж дурсгалын зураг татуулсан юм.



Дэслэгч Ч.БОДЫГЭРЭЛ

ХИЛИЙН ЧАНАДААС

ЗАХИАГААР ДАМЖСАН СЭТГЭЛИЙН ҮГС ЭЗДЭДЭЭ ХҮРЭВ

ИБНАУ-д явагдаж буй “Шийдвэртэй дэмжлэг” олон улсын ажиллагаанд ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэж

Цэргийн алба хаагчдын ээждээ бичсэн захидлыг уран уншигчаар уншуулан бичлэгийг хийж, ээжүүдтэй нь утсаар холбогдон



байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний XIII цэргийн хамгаалалтын ротын эмэгтэй цэргийн алба хаагчдын санаачилгаар “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан “Ээждээ бичих захидал” арга хэмжээг зохион байгуулав.

мэндчилгээ болгон дамжууллаа. Мөн захидлыг ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газраар дамжуулан ээжүүдэд хүргүүлсэн нь тухайн цэргийн алба хаагчид, тэдний ар гэрийг баярлуулсан сайхан арга хэмжээ болж чадсан юм.

Ахлах дэслэгч
П.ОТГОНБААТАР

ДЭЛХИЙД

ЭКВАТОРЫН ГВИНЕЙД ЦЭРГИЙН ХУАРАН ДЭЛБЭРЧ 98 ХҮН АМИА АЛДЛАА

Африк тивийн баруун эрэг, Гвинейн буланд байрлах Экваторын Гвиней улсын Бата боомт хот дахь цэргийн хуаранд хэд хэдэн удаагийн дэлбэрэлт болж 98 хүн амиа алдлаа. Тус улсын хамгийн том цэргийн хуарангуудын нэг Нкоантомагийн ойролцоох хэдэн зуун барилга нурж сүйдсэн ба дэлбэрэлтийн улмаас 615 хүн бэртэж гэмтэн эмнэлэгт хүргэгджээ. 1979 оноос хойш Экваторын Гвинейг удирдаж буй Ерөнхийлөгч Теодоро

Обианг Нгуема дэлбэрэлтийг “динамиттай хайнга харьцсанаас үүдсэн” гэж тайлбарлав. Тус улсын эдийн засгийн дөрөвний гурван хувийг бүрдүүлдэг газрын тосны борлуулалт цар тахлын улмаас буурсан бөгөөд дэлбэрэлт энэхүү эдийн засгийн хямралыг уртасгах эрсдэлтэй байна. 1.4 сая хүн амтай Экваторын Гвинейд өчигдөр коронавируст халдварын 42 тохиолдол бүртгэгдсэнээр нийт халдвар авсан хүний тоо 6371 болсон ба 96 хүн нас баржээ.



Эх сурвалж: AlJazeera



СОЁМБО СОНИН

“Соёмбо” сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор
Хурандаа
САНЖМЯТАВЫН
ТӨМӨРХУЯГ

Эхийг “Соёмбо”
сонини редакцал
бэлтгэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонини нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонини мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хааг:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029